



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

### Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.8, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улаанбаатар хотын аялал жуулчлалын тухай болон хөнгөлөлтийн картаар үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын мэдээлэл бүхий Жуулчин хөнгөлөлтийн ном, картын дизайн, дагалдах сурталчилгааны материалуудын эх зохиох, эх бэлтгэх ажлыг гүйцэтгэх бага үнийн санал ирүүлсэн Модус Студи ХХК-тай хуульд нийцүүлэн гэрээ байгуулж ажиллахыг Мэдээллийн төвүүд хариуцсан менежер /Э.Золзаяа/-т үүрэг болгосугай.

2. Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсөв болох 5,800,000 /Таван сая найман зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА